

Төслийн нэр:	Монголын Санхүүгийн Салбарын Тогтолцоо II (МССТ II)
Улс:	Монгол улс
Төслийн дугаар:	44812
Бизнесийн салбар:	Санхүүгийн байгууллагууд
Төрийн/Хувийн:	Хувийн хэвшил
Захирлуудын зөвлөлийн хурлын товлөгдсөн өдөр:	2014 оны 7-р сарын 23
Төлөв байдал:	Эцсийн шатны хяналт хийгдсэн, захирлуудын зөвлөлөөр батлагдахаар хүлээгдэж байна
ТХББ-ийг нийтэд дэлгэсэн өдөр:	2014 оны 6-р сарын 17
ТХББ-ийг шинэчилсэн өдөр:	
Төслийн тодорхойлолт болон зорилтууд:	<p>ЕСБХБ нь Монгол улсын санхүүгийн салбарт үзүүлж буй дэмжлэгээ цаашид ч үргэлжлүүлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд шинээр 60 сая еврогийн төсөвт өртөгтэй, одоогийн болон шинэ үйлчлүүлэгчдэд зориулсан санхүүжилтийн төсөл хэрэгжүүлэх гэж байна.</p> <p>Энэхүү төсөл нь үндэсний мөнгөн тэмдэгтийн зээлийг багтаасан БЖДБ-ийг дэмжих санхүүжилтийг нэмэгдүүлж, Оролцогч Банкуудын зээл болон эрсдэлийн удирдлагын ур чадварыг сайжруулна.</p> <p>Төслийн хүрээнд хийгдэх анхны санхүүжилт нь дотоодын зээлдэгч нарт олгохоор ХасБанкинд байршуулах 5 сая ам.долларын БЖДБ-ийн зээл байна.</p>
Дэд төслүүд:	Энэ төслийн болон тогтолцооны бусад төслүүдийн дэд-төслүүдийн жагсаалтыг харна уу.
Шилжилтийн үеийн нөлөөлөл:	Санал болгож буй төслийн шилжилтийн үеийн нөлөөлөл нь дараах эх үүсвэрүүдээс бүрэлдэнэ. Үүнд: (i) Монгол улс дахь санхүүгийн зуучлах үйлчилгээг цаашид илүү сайжруулж, БЖДБ-ийн салбарт дунд хугацаат санхүүжилт олгох, (ii) шинэ бүтээгдэхүүний нээлт, хөгжлийг дэмжих (жишээ нь Нэмүү өртгийн сүлжээний

	санхүүжилт), улмаар БЖДБ-т зориулсан санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах, (iii) шинэ Оролцогч Банкуудыг хамруулах, (iv) Оролцогч Банкуудад бизнесийн зарчим, арга барил, эрсдэлийн удирдлагаа сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх явдал орно.
Үйлчлүүлэгчид:	Монгол улсын арилжааны банкууд. Тогтолцооны хувьд хамгийн эхний санхүүжилтийг хүлээн авах ХасБанк нь хэмжээгээрээ Монгол улсын дөрөв дэх том банк бөгөөд 1.1 тэрбум ам.долларын актив, 109 сая ам.долларын өөрийн хөрөнгөтэй. ХасБанк бол жижиглэн болон БЖДБ-ийн чиглэлд илүү дагнан ажилладаг, нэлээд өргөн хүрээг хамарсан олон салбар сүлжээ бүхий банк.
ЕСБХБ-ны санхүүжилт:	60 сая евро Санхүүгийн тогтолцоо
Төслийн нийт өртөг:	60 сая евро
Байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийн ангилал, үр нөлөө, хор хөнөөлийг арилгах арга хэмжээ:	<p>FI Ангилал. Энэхүү үйлчилгээнд хамрагдах бүх Оролцогч Банкууд (цаашид “ОБ” гэх) ЕСБХБ-наас тавьдаг гүйцэтгэлийн шаардлага 2 ба 9-ийг тус тус хангаж ажиллах ёстой.</p> <p>Ингэхдээ ЕСБХБ-ны Байгаль орчин болон нийгмийн асуудлаар баримтлах дүрэм журам болон Ажил үүргийн жагсаалтыг баримтлах; үйлчлүүлэгчдийн хувьд байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал болон хөдөлмөр хамгааллын үндэсний зохицуулалт, стандартуудад нийцүүлэх; мөн цахим гарын авлагад тусгасан Жижиг болон бичил зээл олгохтой холбоотой Байгаль орчны ба нийгмийн хүрээнд баримтлах дүрэм журмыг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.</p> <p>Төсөлд хамрагдах бүх шинэ ОБ-ууд ЕСБХБ-ны Хүний нөөцийн үнэлгээ шалгалтын асуумж болон Байгаль орчин нийгмийн үнэлгээ шалгалтын асуумжийг бөглөх, тэдгээрийг ЕСБХБ-нд илгээж хянуулах замаар гүйцэтгэлийн шаардлага 2 ба 9-ийг тус тус хангаж ажиллах ёстой.</p> <p>Шинэ ОБ-уудын дунд байгаль орчны болон нийгмийн үнэлгээ шалгалтын талаарх сургалт зохион байгуулах боломжтой. Бүх ОБ-ууд жил тутмын байгаль орчны болон нийгмийн үйл ажиллагааны тайлангаа ЕСБХБ-нд хүргүүлэх үүрэг хүлээнэ.</p>
Техникийн хамтын	Монголын Санхүүгийн Салбарын Тогтолцоо II төслийг хэрэгжүүлэх явцад Оролцогч Банкуудын чадавхыг

ажиллагаа:	бэхжүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл тухайн нөхцөл байдал тус бүрт нийцүүлэн шинээр техникийн хамтын ажиллагаа (ТХА)-ны хүсэлт гаргана. Эрсдэлийн удирдлага, шинэ бүтээгдэхүүний төлөвлөлт, нээлт, байгууллагын чадавхи бэхжүүлэх болон компанийн засаглал гэсэн чиглэлүүдэд ТХА авч хэрэгжүүлэх шаардлага тулгарна гэж үзэж байна.
Компанийн холбоо барих мэдээлэл:	ХАС Банкны Төв Байр Улаанбаатар-14200 Шуудангийн салбар 20А Шуудангийн хайрцаг-721 Монгол Улс Утас: +976 11 318185 Факс: +976 11 328701 Цахим шуудан: info@xacbank.mn Вэб хуудас: www.xacbank.mn
Бизнесийн боломжууд:	Бизнесийн боломжууд болон худалдан авалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.
Ерөнхий лавлагаа:	ЕСБХБ-ны төслийн худалдан авалтаас бусад асуудлуудын талаарх мэдээллийг дараах холбоо барих утас, факс болон цахим шуудангийн хаягаар авна уу: Утас: +44 20 7338 7168; Факс: +44 20 7338 7380 Цахим шуудан: projectenquiries@ebrd.com
Олон нийтийн мэдээллийн бодлого (ОНМБ)	Олон нийтийн мэдээллийн бодлого (цаашид “ОНМБ” гэх) нь ЕСБХБ-ны зүгээс холбогдох мэдээллийг олон нийтэд хэрхэн түгээх, хувь нийлүүлэгч, хамтрагч талуудтайгаа хэрхэн зөвшилцөх, өөрийн стратеги, бодлого, үйл ажиллагааг сурталчлах, ойлголт мэдлэгийг нь нэмэгдүүлэх талаар баримтлах зарчмуудыг тусган харуулсан байдаг. ОНМБ-ын текстийг дараах холбоосоор орж авна уу: http://www.ebrd.com/about/policies/pip/index.htm
Төслийн гомдол барагдуулах тогтолцоо (ТГБТ):	ЕСБХБ нь өөрийн санхүүжүүлсэн төслүүдийн үйл ажиллагаанаас хэн нэгэнд ямарваа хор хохирол учруулсан буюу учруулж болзошгүй талаар нэг буюу түүнээс олон тооны хувь хүн, албан байгууллагын зүгээс мэдүүлсэн гомдлыг хараат бус байдлаар нэг бүрчлэн авч үзэх, хянах боломжийг олгох үүднээс Төслийн гомдол барагдуулах тогтолцоо (цаашид “ТГБТ” гэх)-г бий болгосон. ТГБТ-ны үйл ажиллагааг удирдан

чиглүүлдэг Дотоод дүрэм журмыг Англи хэл дээр www.ebrd.com/downloads/integrity/pcmrules.pdf, холбоосоор, Орос хэл дээр <http://www.ebrd.com/downloads/integrity/pcmrulesr.pdf>

холбоосоор орж авна уу.

ТГБТ-ны дагуу аливаа гомдлыг ЕСБХБ-ны санхүүжилтийн сүүлийн хуваарилалт хийгдсэнээс хойш 12 сарын дотор бүртгэж шийдвэрлэх ёстой. Гомдлоо ямар хугацаанд хэрхэн ирүүлэх талаар тодруулах, туслалцаа авахыг хүсвэл pcm@ebrd.com хаягаар ТГБТ-ны ажилтантай холбогдох буюу ЕСБХБ-ны төлөөлөгчийн газарт хандана уу.
